

**ГЛОБАЛЬ САНГИЙН ДЭМЖЛЭГТЭЙ ДОХ, СҮРЬЕЭГИЙН
ТӨСӨЛД ЭРҮҮЛ МЭНДИЙН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ, ӨР ХӨРВҮҮЛЭХ НЭМЭЛТ
ТӨСӨЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН СОНГОН ШАЛГАРУУЛАХ УРИЛГА**

Глобаль сангийн дэмжлэгтэй 16 дахь удаагийн ДОХ, сүрьеэгийн төсөл нь 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж байгаа бөгөөд Эрүүл мэндийн яам төслийн үндсэн хүлээн авагч байгууллагаар ажиллаж байна.

Эрүүл мэндийн яам нь Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн нэгжид “Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх, өр хөрвүүлэх” төсөл хариуцсан мэргэжилтний сонгон шалгаруулалтыг зарлаж байна. Тус мэргэжилтэн Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”, Монгол Улс ХБНГУ-ын Засгийн Газар хооронд байгуулсан “Өр хөрвүүлэх хэлэлцээр”-ийн /D2H/ дагуу төслийн хэрэгжилтийг ханган ажиллана.

Ажлын байрны гүйцэтгэх чиг үүрэг:

- Эрүүл мэндийн яам болон төслийн зохицуулагч, багийн гишүүдтэй нягт хамтран D2H төслийг үр дүнтэй хэрэгжүүлэх, эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэхэд ДОХ, сүрьеэгийн хөтөлбөрийг уялдуулан ажиллах;
- Эрүүл мэндийн яам болон орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажиллаж, төслийн үйл ажиллагааг эрүүл мэндийн тэргүүлэх чиглэл, стратегийн төлөвлөгөөнд нийцүүлэх, нөөцийг үр ашигтай зарцуулахад анхаарах;
- “Өр хөрвүүлэх хэлэлцээр”-ийн нэмэлт санхүүжилтийн үйл ажиллагааны цогц төлөвлөгөөг боловсруулж, эрүүл мэндийн тогтолцооны бэхжүүлэлт, өвчний нэгдсэн хөтөлбөр, тогтвортой санхүүжилтийн стратегийг тодорхойлох;
- ДОХ, сүрьеэгийн хөтөлбөр болон эрүүл мэндийн санхүүжилтийн асуудалтай холбоотой эрсдэл, сорилтуудыг тодорхойлж, шийдвэрлэх арга замыг санал болгох
- Төслийн хэрэгжилтийг тогтмол хянаж, хугацаа, төсөв, чанарын стандартыг ханган, оновчлол хийх боломжийг тодорхойлох;
- Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар болон бусад байгууллагуудтай хамтран ДОХ, сүрьеэгийн хөтөлбөрийг тогтвортой санхүүжүүлэх стратегийг боловсруулах, хэрэгжүүлэх;
- Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилт зэрэг механизмуудыг ашиглан ДОХ, сүрьеэгийн хөтөлбөрийг тогтвортой санхүүжүүлэх боломжийг бүрдүүлэх;
- “Өр хөрвүүлэх хэлэлцээр”-ийн төслийн хүрээнд эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх, өвчний нэгдсэн хөтөлбөрийн үр дүнг үнэлэх хяналт-шинжилгээний тогтолцоог бий болгох
- Төслийн үр дүн, санхүүгийн төлөв, хэрэгжилтийн явцыг Төслийн зохицуулагч, үндэсний түвшний оролцогч талуудад тогтмол тайлагнах;
- Эрүүл мэндийн тогтолцооны чадавхын хэрэгцээг үнэлж, эрүүл мэндийн санхүүжилтийн хүрээнд ДОХ, сүрьеэгийн хөтөлбөрийг удирдах чадамжийг дээшлүүлэх;
- Төслийн хэрэгжилтийг сайжруулахын тулд эрүүл мэндийн ажилтнуудад сургалт, техникийн туслалцаа үзүүлэх;
- Бодлогын баримт бичиг, тайлан, мэдээллийн материал боловсруулж, оролцогч талуудад танилцуулах.

Ажлын байрны шаардлага:

1. Анагаах ухаан, эрүүл мэнд, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр их дээд сургууль төгссөн, холбогдох чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх;
2. Үндэсний ба олон улсын түвшинд төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, эрүүл мэндийн тогтолцоо бэхжүүлэх чиглэлээр 5-аас дээш жил ажилласан туршлагатай байх;
3. Англи хэлний B2, C1 түвшний мэдлэгтэй байх;
4. Компьютерын хэрэглээний программууд дээр ажиллах чадвартай байх;

5. Бие даан болон багаар ажиллах чадвартай байх;
6. Эрдэм шинжилгээний болон судалгааны ажлын арга зүйд суурилсан бодлогын дүн шинжилгээ хийх чадвартай байх;
7. Глобаль сангийн дэмжлэгтэй төслүүдийг олон нийтийн өмнө танилцуулах, төлөөлөх, илтгэх өндөр ур чадвартай.

Дараах материалыг бүрдүүлэн 2026 оны 05 дугаар сарын 06 -ны өдрийн 17.30 цаг хүртэл Эрүүл мэндийн яамны бичиг хэргийн ажилтанд битүүмжилсэн байдлаар ирүүлнэ үү.

1. Төрийн албан хаагчийн анкет (Маягт №1);
2. Иргэний үнэмлэхийн хуулбар;
3. Боловсролын түвшин тодорхойлсон баримт бичиг (диплом)-ийн хуулбар (гадаадад их, дээд сургууль төгссөн бол баталгаат орчуулгын хамт);
4. Тухайн албан тушаалд томилогдох хүсэлт (өөрийн мэдлэг, ур чадвараа илэрхийлсэн байх);
5. 5-аас дээш жилийн хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлсөн лавлагаа (E Mongolia-с авсан лавлагаа);
6. Англи хэлний мэдлэгийн түвшнийг нотлох баримт бичиг;
7. Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт;
8. Тухайн ажлын байрны чиг үүрэгтэй холбогдуулан мэргэшсэн байдал, ажлын туршлага болон бусад тусгай шаардлагыг нотлох баримт бичиг, олон улсын байгууллагад ажиллаж байсан бол гэрээ, өмнө нь ажиллаж байсан байгууллагын тодорхойлолтын хамт ирүүлнэ үү.

Хаяг: Эрүүл мэндийн яам, Засгийн газрын VIII байр, Олимпын гудамж-2, Сүхбаатар дүүрэг 14210, Улаанбаатар хот.

Холбогдох утас: 51-261629, 70008010.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ